

**“МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙГ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХҮРЭЭНД ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 05 дугаар
сарын 31-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлого, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дэлхийн зах зээлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлага, түүхий эдийн нөөцөд тулгуурлан “Цагаан алт” болсон малын гаралтай түүхий эдээ бүрэн ашиглаж, үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүн болгох, дотооддоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан “Цагаан алт” хөдөлгөөнийг өрнүүлэх хүрээнд “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулжээ.

Тогтоолын төсөл батлагдсанаар нийгэмд ямар нэгэн сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд олон улсын стандартад нийцсэн өрсөлдөх чадвартай, гарал үүсэл, чанарын баталгаатай, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт нэмэгдэж, малын гаралтай түүхий эдийн үнэ цэнэ сайжрах эрх зүйн орчин бүрдэнэ гэж үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэр нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд хэрхэн тусгагдсан, мөн холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад зохицуулалт хийн санхүүжүүлэх боломжтой эсэх талаар тодруулж, хариулт авлаа.

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал,

дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Г.ГАНБОЛД